



Australia Awards

МОНГОЛ УЛС

Австралийн тэтгэлэгт хөтөлбөрт өргөдөл гаргах

Монгол дахь Австралийн тэтгэлэгт хөтөлбөр

Австралийн тэтгэлэг нь дэлхийн хөгжлийн ирээдүйг тодорхойлох манлайлагчдыг бэлтгэдэг Австралийн Засгийн газраас санхүүжүүлдэг тэтгэлэг юм. Тэтгэлэгт шалгаргагсад Монгол - Австралийн харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулахын зэрэгцээ Австралид суралцан мэдлэг, судалгааны арга барил, мэргэжлээ дээшлүүлснээр нийгэмд эерэг өөрчлөлт бий болгоно.

Өргөдөл гаргагчдыг мэргэжлийн болон хувь хүний чадамж, суралцах чадвар, нэн ялангуяа Монгол Улсад тулгамдаж буй хөгжлийн сорилтуудыг шийдвэрлэхэд оруулах хувь нэмрийг харгалзан үнэлж, сонгодог.

Хөдөө, орон нутгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нийгмийн цөөнхийг тэтгэлэгт өргөдөл гаргахыг дэмжинэ.

Суралцах тэргүүлэх салбарууд

Суралцах тэргүүлэх салбарууд:

- Хөдөө аж ахуй, байгаль орчин судлал
- Боловсрол
- Инженерчлэл, уул уурхай, барилга
- Эрүүл мэнд
- Мэдээлэл, харилцаа холбооны технологи
- Менежмент, бизнес, худалдаа
- Төрийн удирдлага
- Нийгэм, соёл ба хөгжил судлал

Суралцах тэргүүлэх салбар, чиглэлийг жил бүр Австрали, Монгол Улсын Засгийн газар хянаж, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчилдөг. Тэргүүлэх салбар чиглэлүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг **Монгол дахь Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн** цахим хуудсаас үзнэ үү.

Суралцах салбар, чиглэлээ сонгохдоо Австрали Улсын **Гадаад оюутнуудад зориулсан боловсролын институт, сургалтын нэгдсэн мэдээллийн санг** ашиглахыг зөвлөж байна. <https://cricos.education.gov.au/default.aspx>

Суралцах түвшин

Тэтгэлэг нь Монгол Улсын иргэдэд Австралийн их сургуулиудад бакалаврын дараах түвшний боловсролын зэрэг олгох сургалтанд хамрагдах боломж олгодог.

2023 оны тэтгэлгийг дараах ангиллаар олгоно:

Ангилал 1: Нийт тэтгэлгийн 50 хувийг төрийн албан хаагчдад олгоно.

Ангилал 2: Нийт тэтгэлгийн 50 хувийг хувийн хэвшил, иргэний нийгмийн болон олон улсын байгууллагын албан хаагчдад олгоно.

Тэтгэлгийг **Танхимын болон Судалгааны магистрын хөтөлбөрт** олгоно.

Австралийн тэтгэлгийн үр шим

Австралийн тэтгэлгийн хугацаа нь Австралийн их сургуулиас санал болгосон академик болон бэлтгэл сургалтыг дүүргэх хамгийн богино хугацаагаар тодорхойлогдоно.

Австралийн тэтгэлэгт дараах дэмжлэг багтана. Үүнд:

- Австралид ирж, буцах нислэгийн зардал
- Австралид очиж суурьших нэг удаагийн тэтгэмж
- Сургалтын бүрэн төлбөр
- Амьжиргааны зардал
- Академик сургалтын удиртгал хөтөлбөр
- Оюутан байх хугацааны эрүүл мэндийн даатгал
- Академик сургалтад олгох нэмэлт дэмжлэг
- Судалгааны ажлын зардал (зөвхөн судалгаа хийж буй оюутанд болон танхимын магистрын дадлага хийх оюутнуудад хамаарна).

Болзол шалгуурууд

Австралийн тэтгэлэгт өргөдөл гаргагчид dfat.gov.au/about-us/publications/Pages/australiaawards-scholarships-policy-handbook.aspx холбоост байрших **“Австралийн тэтгэлгийн бодлогын гарын авлага”**-д дурдсан бүх ерөнхий шалгуурыг хангасан байна.

Англи хэлний шалгуур

Тэтгэлэгт сонгогдсон өргөдөл гаргагч сургалтаа эхлүүлэхээс өмнө Academic IELTS-ийн голч оноо 6.5 болон



түүнээс дээш (нэгж оноо 6.0-аас доошгүй) эсвэл iBT-TOEFL эсвэл PTE-ийн дүйцэх онооны шалгуурыг хангана.

Монгол Улсад тавигдах тусгай шалгуурууд

Монгол Улсаас өргөдөл гаргагчид нь дараах тусгай шалгууруудыг хангах ёстой. Үүнд:

- Өргөдөл гаргагчид бүтэн цагаар суралцсан бакалаврын дипломтой, голч оноо 3.0 болон түүнээс дээш байна. Хэрэв тухайн бакалаврын дипломд дүнгийн голч оноог тодорхой заагаагүй бол өргөдөл гаргагч нь төгссөн их, дээд сургуулиасаа голч онооны тодорхойлолт авах ёстой.
- Өргөдөл гаргагчид 2023 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар хүчинтэй Academic IELTS-ийн голч оноо 6.0 (нэгж оноо 5.5-аас доошгүй) эсвэл iBT-TOEFL, PTE-ийн дүйцэх оноотой байна. Хэрвээ тэтгэлэгт сонгогдвол, Монгол Улсад явагдах англи хэлний 6 хүртэл сарын сургалтанд хамрагдах боломж бүрдэнэ. Англи хэлний сургалтанд хамрагдсаны дараа IELTS-ийн 6.5 онооны шалгуурыг хангаагүй нөхцөлд тэтгэлэг цуцлагдана.
- Өргөдөл гаргагчид 2022 оны 2 дугаар сарын 1-ний байдлаар хоёр болон түүнээс дээш жил тасралтгүй хөдөлмөр эрхэлсэн гэдгээ нотлоно (хүүхэд асрах чөлөөний хугацааг оруулж тооцно). Харин хөгжлийн бэрхшээлтэй гэдгээ мэдүүлж, нотолсон өргөдөл гаргагчдад энэ шаардлага хамаарахгүй. Нэгдүгээр ангиллаас өргөдөл гаргагчид 2022 оны 2 дугаар сарын 1-ний байдлаар төрийн албанд хоёр ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй гэдгээ мэдүүлж, нотолсон өргөдөл гаргагчдад хоёр жил тасралтгүй хөдөлмөр эрхэлсэн байх шаардлага тавигдахгүй. Хөгжлийн бэрхшээл гэдэг тодорхойлолт, ангилал нь Австрали ба Монгол Улсын хууль, эрх зүйн хүрээнд ялгаатай тодорхойлогддог бөгөөд архаг, суурь өвчнийг Австрали Улсад хөгжлийн бэрхшээл гэж хүлээн зөвшөөрдөггүйг анхаарна уу. Дэлгэрэнгүй мэдээллийг **“Австралийн тэтгэлгийн бодлогын гарын авлага”**-аас харна уу.

Санамж: Тасралтгүй ажилласан жилийг зөвхөн бүтэн цагийн бакалаврын болон магистрын зэргээ хамгаалсан өдрөөс хойш тооцож, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр баталгаажуулна. Сайн дурын нийгмийн даатгалын бичилтээр хөдөлмөр эрхлэлтийг баталгаажуулахгүй.

Санамж: Өмнө нь гадаадад магистрын түвшний боловсрол эзэмшсэн өргөдөл гаргагчид Австралийн тэтгэлэгт ижил чиглэлээр өргөдөл гаргахыг зөвшөөрөхгүй.

Өргөдөл хүлээн авах хугацаа

2023 оны тэтгэлгийн өргөдлийг дараах хугацаанд хүлээн авна. Үүнд:

Эхлэх өдөр: 2022 оны 2 дугаар сарын 1

Дуусах өдөр: 2022 оны 4 дүгээр сарын 29 (23:59 AEST-Зүүн Австралийн стандарт цаг)

Хугацаа хоцорсон өргөдөл болон дагалдах бичиг баримтыг хүлээн авахгүй бөгөөд хүчингүйд тооцно.

Өргөдөл гаргах үйл явц

Цахим өргөдөл

Бүх өргөдөл гаргагчид <https://oasis.dfat.gov.au/> цахим хуудсаар дамжуулан өргөдөл гаргана.

Бүрдүүлэх бичиг баримтууд

Өргөдөл гаргагчид **“Австралийн тэтгэлгийн бодлогын гарын авлага”**-д заасан бичиг баримтыг бүрдүүлж, өргөдөлд хавсаргана.

Түүнчлэн өргөдөл гаргагчид Монгол Улсын иргэдэд тавигддаг шалгуурын дагуу дараах бичиг баримтыг бүрдүүлэн, цахим өргөдөлд хавсаргана. Үүнд:

Бичиг баримт	OASIS ангилал	Нотариатаар баталгаажуулах эсэх
Төрсний гэрчилгээ (эх материалын хуулбар ба англи орчуулга)	Иргэншил батлах	Тийм
Монгол Улсын иргэний үнэмлэх	Иргэншил батлах	Үгүй
Дээд боловсролын гэрчилгээ (бакалавр, магистрын түвшин; эх материалын хуулбар ба англи орчуулга)	Боловсролын гэрчилгээ	Тийм
Дипломын хавсралт (эх материалын хуулбар ба англи орчуулга). Хэрэв бакалаврын дипломд дүнгийн голч оноог тодорхой заагаагүй бол өргөдөл гаргагч тухайн их, дээд сургуулиас голч онооны тодорхойлолт авах ёстой)	Дүнгийн хавсралт	Тийм
Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаар тодорхойлолт (2020 оны 2-р сарын 1-нээс 2022 оны 2-р сарын 1-ний хооронд шимтгэл төлж, баталгаажуулсан байна) Жич: Хөгжлийн бэрхшээлтэй гэдгээ мэдүүлж, нотолсон өргөдөл гаргагчдад үл хамаарна. Жич: Албан журмаар нийгмийн даатгалаас чөлөөлөгдсөн өргөдөл гаргагчид Монгол дахь Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн газартай холбогдож зөвлөмж авна уу.	Бусад бичиг баримт	Үгүй

Academic IELTS, iBT-TOEFL эсвэл PTE-ийн гэрчилгээний хуулбар	Англи хэлний түвшинг батлах	Үгүй
Одоо хөдөлмөр эрхэлж буйг тодорхойлсон ажил олгогчийн албан захидал (байгууллагын тамгатай монгол эх хувь ба англи орчуулга) Жич: Хөгжлийн бэрхшээлтэй гэдгээ мэдүүлж, нотолсон өргөдөл гаргагчдад үл хамаарна.	Ажил олгогчийн албан бичиг	Үгүй
Академик тодорхойлолт (тамгатай) <i>Танхимын магистрын өргөдөл гаргагчид нэг, Судалгааны магистрын өргөдөл гаргагчид хоёр тодорхойлолтууд хавсаргана. Хэрэв тодорхойлолтууд монгол хэл дээр бол англи орчуулга хэрэгтэй. Маягтын загварыг OASIS болон Монгол дахь Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн цахим хуудаснаас татаж авна.</i>	Тодорхойлолт	Үгүй
Ажил байдлын тодорхойлолт. (Тодорхойлолтыг дээрх загварын дагуу бичнэ. Монгол хэл дээр бол англи орчуулгыг хавсаргана.) Жич: Хөгжлийн бэрхшээлтэй гэдгээ мэдүүлж, нотолсон өргөдөл гаргагчид үл хамаарна.	Тодорхойлолт	Үгүй
Товч намтар (Англи хэл дээр. Хөтөлбөрийн цахим хуудсанд байрлуулсан загварын дагуу бичнэ.)	Товч намтар	Үгүй
Буцаан байршуулах төлөвлөгөө, (Хөтөлбөрийн цахим хуудсанд байрлуулсан загварын дагуу бичнэ.)	Бусад бичиг баримт	Үгүй

Бэлтгэл сургалт

Тэтгэлэгт урьдчилсан байдлаар шалгарагсад дараах сургалт семинарт хамрагдана. Үүнд:

- Курсын талаарх зөвлөгөө
- Үдэлтийн өмнөх сургалт семинар
- Academic IELTS-ийн 6.5-аас доош, гэхдээ 6.0 оноогоос доошгүй (iBT-TOEFL эсвэл PTE-ийн дүйцэх оноотой) тэтгэлэгт урьдчилсан байдлаар шалгарагсад Монгол

улсад зохион байгуулагдах 6 хүртэл сарын англи хэлний сургалтанд заавал хамрагдана

- Тэтгэлгийн болзол шалгуурыг хангасан өргөдөл гаргагчид Монгол Улсад зохион байгуулагдах Академик бэлтгэл хөтөлбөрт хамрагдана
- Австрали Улсад зохион байгуулагдах бусад бэлтгэл сургалт

Сонгон шалгаруулах үйл явц

- Өргөдөл хаагдсаны дараа өргөдөл тус бүрийг тэтгэлгийн болзол шалгуур хангасан эсэхийг шалгаж, бичиг баримтын бүрдүүлэлт, тэдгээрийн хүчинтэй эсэхийг нягтална.
- Зөвхөн хураангуй жагсаалтад багтсан өргөдөл гаргагчидтай холбогдоно.
- Сонгон шалгаруулалтад ярилцлага багтана. Ярилцлага дараах шалгуур үзүүлэлтээр хийгдэнэ.
Үүнд:
 - Суралцах чадвар
 - Монгол Улсад тулгамдаж буй хөгжлийн сорилтуудыг шийдвэрлэхэд оруулах хувь нэмэр
 - Мэргэжлийн болон хувь хүний манлайллын чадвар, зохих ажлын туршлага
- Тэтгэлэгт урьдчилсан байдлаар шалгарагсад сонгон шалгаруулалтын дүнг 2022 оны 9 дүгээр сард мэдэгдэнэ.
- Тэтгэлэгт шалгарагсад Австрали Улс руу зорчихдоо Австралийн Засгийн газар, тус улсын Боловсрол, ур чадвар, хөдөлмөр эрхлэлтийн яам болон Австралийн муж, нутаг дэвсгэрийн захиргаанаас тавих шалгууруудыг хангах ёстой.

Дэлгэрэнгүй мэдээлэл

Монгол дахь Австралийн тэтгэлгийн талаарх мэдээллийг доорх холбоосоор орж үзнэ үү:

www.australiaawardsmongolia.org

Австралийн тэтгэлэг, Австралийн Хөгжлийн хөтөлбөр, Австралид суралцах талаар ерөнхий мэдээллийг доорх холбоосоор орж үзнэ үү:

- dfat.gov.au/people-to-people/australia-awards/Pages/australia-awards-scholarships
- studyinaustralia.gov.au

Австралийн тэтгэлгийн үр шим, болзол шалгуур, визний талаар мэдээллийг **“Австралийн тэтгэлгийн бодлогын гарын авлага”** – ыг орж үзнэ үү.

Холбоо барих хаяг:

Монгол дахь Австралийн тэтгэлэгт хөтөлбөр
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг Сүхбаатарын талбай-2, 14200, Сэнтрал Тауэр, 512В тоот

Утас: +976-11-318852/+976-94329543

Цахим шуудан: info@australiaawardsmongolia.org